



**МОНГОЛ УЛСЫН
ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА
ХОЛБООНЫ ЯАМ**

Сүхбаатарын талбай 1, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, 15160
Утас: 33 07 81, Факс: (976-11) 33 07 80,
Цахим шуудан: info@mddc.gov.mn
Цахим хуудас: www.mddc.gov.mn

2022.10.21. № 03/1809
танай _____-ны № _____-Т

**МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ
АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН
АЖЛЫН АЛБАНД**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 5 дугаар зарлигаар батлагдсан “Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах журам”-ын дагуу тус яамны 2022 онд хамаарах мэдээ, тайланг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 8...хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА



Ч.ЗОЛБАЯР

995616

Цахим хөгжил, харилцаа холбооны яамны
2022 оны 10 дугаар сарын 21-ны өдрийн
03/1809 дугаар албан бичгийн хавсралт

МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ 2022 ОНЫ ТАЙЛАН, МЭДЭЭ

1. Мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр хийсэн ажлын талаар

Цахим гарын үсгийн тухай, Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Кибер аюулгүй байдлын хууль батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 13 дугаар захирамжаар шинээр батлагдсан хуульд заасан журам, дүрэм, жагсаалтын боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан ажилласан. Ажлын хэсгийн хүрээнд кибер аюулгүй байдлын хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-т заасан 17 чиглэлийн үйл ажиллагаа бүхий онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй төрийн болон хувийн хэвшлийн нийт 216 байгууллагын жагсаалт гаргаж, Засгийн газрын 2022 оны 207 дугаар тогтоолоор батлуулсан.

Мөн Төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээг байгуулах, ашиглах журам болон төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбогдох байгууллагын жагсаалтыг тагнуулын байгууллагатай хамтран боловсруулж, Засгийн газрын 2022 оны 197 дугаар тогтоолоор батлуулсан.

Кибер аюулгүй байдлын үндэсний стратеги боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг 10 байгууллага, 18 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны А/05 дугаар тушаалаар байгуулсан. Ажлын хэсгийн хүрээнд Кибер аюулгүй байдлыг хангах чиглэлээр тэргүүлэгч орнууд болон манай улстай ойролцоо үзүүлэлттэй улсын кибер аюулгүй байдлын стратегийг судалж, кибер аюулгүй байдлын өнөөгийн түвшинд тулгуурлан Монгол Улсын кибер аюулгүй байдлын үндэсний стратегийг 5 зорилт, 47 үйл ажиллагаатайгаар боловсруулж, Засгийн газрын гишүүдээс санал авч нэгтгэж байна.

Кибер аюулгүй байдлын хууль тогтоомж, холбогдох журам, стандартад нийцсэн эсэхэд дүгнэлт гаргах, зөвлөмж өгөх хараат бус хөндлөнгийн мэргэжлийн үйл ажиллагаа бүхий мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх этгээдийг бүртгэх, аудит хийх журмын төсөл, цахим мэдээлэл, мэдээллийн систем, мэдээллийн сүлжээний кибер аюулгүй байдал алдагдах, аюул занал тохиолдох магадлал, эмзэг байдлын түвшин, түүнээс үүсэх үр дагавар, эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг тодорхойлох мэргэшсэн үйл ажиллагаа бүхий кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх журам, аргачлалын төслийг боловсруулж, олон нийтээс санал авч байна. Эдгээр журмын төсөл батлагдсанаар аудит болон эрсдэлийн үнэлгээ хийх хуулийн этгээдийг бүртгэх, онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагын мэдээллийн систем, сүлжээний эмзэг байдлыг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангах боломж сайжирна.

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд хуулиар зөвшөөрснөөс бусад мэдээлэл хариуцагчийн цуглуулсан биеийн давхцахгүй өгөгдөл /гарын хурууны хээ/-ийг устгахаар заасны дагуу Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 55 дугаар захирамжаар 16 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй Ажлын хэсэг байгуулагдаж, мэдээлэл хариуцагчийн цуглуулсан биеийн давхцахгүй өгөгдлийг устгах үйл ажиллагааг зохион байгуулсан.

Ажлын хэсгийн хүрээнд 10863 байгууллагаас 2464 байгууллага нь хурууны хээ бүртгэх зориулалт бүхий систем, тоног төхөөрөмж ашиглан 637024 хэрэглэгчийн хурууны хээ цуглуулсан байсныг устгуулсан.

Мөн дуу, бичлэгийн төхөөрөмж байршуулахад тавих шаардлага, зааварчилгааны төслийг боловсруулж, байгууллагын цахим хуудсаар дамжуулан олон нийтээс санал авч байна.

Мэдээлэл хариуцагч хүний оролцоогүй цахим хэлбэрээр боловсруулалт хийх технологийг ашиглан мэдээлэл цуглуулж, боловсруулж, ашиглахад үнэлгээ хийх аргачлал, журмын төсөл, Мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах үед мэдээллийн аюулгүй байдлыг хангах шаардлага, үнэлгээ хийх зааварчилгаа, хадгалах технологид тавигдах шаардлагын төслийг тус тус боловсруулж байна.

Цахим гарын үсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулга хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэнтэй холбогдуулан Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны А/28 дугаар тушаалаар “Төрийн албан хаагчид тоон гарын үсгийн гэрчилгээ олгох, түүнийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох журам”, 2022 оны А/30 дугаар тушаалаар “Тоон гарын үсгийн гэрчилгээний үндэсний санг бүрдүүлэх, ашиглах журам”-ыг тус тус баталж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн.

Тоон гарын үсгийн гэрчилгээ олгох тусгай зөвшөөрөл эзэмшигч 4 байгууллагын тусгай зөвшөөрөл, гэрчилгээний хугацааг шинэчлэн олгосон. Мөн Улсын бүртгэлийн байгууллагад тоон гарын үсгийн гэрчилгээ олгох эрхийг шинээр үүсгэсний дагуу Улсын бүртгэлийн байгууллагаас 21 аймаг, 330 сум, 9 дүүрэг, 171 хорооны бүртгэлийн нэгжээр дамжуулан нийт 229,526 иргэнд тоон гарын үсгийн гэрчилгээг олгоод байна.

Тоон гарын үсгийн гэрчилгээ олгох тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудаас нийт 79482 хуулийн этгээдэд, “Үндэсний дата төв” УТҮГ-аас 13210 төрийн албан хаагчид тоон гарын үсгийн гэрчилгээ тус тус олгосон. Иргэн, хуулийн этгээд тоон гарын үсэг ашиглан танилт, нэвтрэлтийн систем ашигладаг төрийн 41 байгууллагын 163 систем, хувийн хэвшлийн 106 байгууллагын 236 системээр дамжуулан цахим хэлбэрээр үйлчилгээ авах боломжтой болгосон.

Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.8-т заасан кибер халдлага, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх, холбогдох хууль тогтоомжийг сурталчлах ажлын хүрээнд “Кибер аюулгүй байдал, халдлагад үзүүлэх хариу арга хэмжээ”-ний талаар мэдлэг ойлголт өгөх багц сургалтыг 2022 оны 09 дүгээр сард цахим болон танхимын хэлбэрээр төрийн 45 байгууллагын 136 албан хаагч, онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй 166 байгууллагын 427 инженер техникийн ажилтан, нийт 563 инженер ажилтан, албан хаагчдыг хамруулан зохион байгуулсан.

Америкийн нэгдсэн улсын Төрийн Департамент болон тус улсын MITRE байгууллагатай хамтран 2022 оны 9 дүгээр сард “Үндэсний кибер аюулгүй байдлын боловсон хүчний хөгжил” сэдвээр төрийн байгууллагаас 20 албан хаагч, хувийн хэвшлийн байгууллагаас 12 ажилтан, боловсролын байгууллагын 6 багш, нийт 38 төлөөлөгчийг хамруулан кибер аюулгүй байдлыг хангах хүний нөөцийг хөгжүүлэх нөхцөл боломжийн талаар сургалт зохион байгуулж туршлага солилцсон.

Мөн АНУ-ын Карнеги Меллоны Их Сургуультай байгуулсан хамтын ажиллагааны хүрээнд кибер аюулгүй байдлыг хангах боловсон хүчний чадавхыг дээшлүүлэх зорилгоор “Компьютерын аюулгүй байдал, халдлагад хариу үзүүлэх баг (CSIRT) байгуулах нь” сэдэвт сургалтыг 2022 оны 02 дугаар сард цахим хэлбэрээр зохион байгуулсан. Сургалтад төрийн болон хувийн хэвшлийн нийт 20 байгууллагын 34 албан хаагчийг хамруулж, компьютерын аюулгүй байдал, халдлагад хариу үзүүлэх багийг байгуулах, тухайн багаас үзүүлж болох үйлчилгээ болон байгууллагууд дээрх багтай хэрхэн хамтарч ажиллах талаар мэдээлэл өгсөн.

Иргэд, олон нийтийн мэдээллийн аюулгүй байдлын мэдлэг ойлголтыг дээшлүүлэх, соён гэгээрүүлэх зорилтын хүрээнд АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг /USAID/-ийн санхүүжилтээр хэрэгжиж буй “Миний Минийх” нэртэй компанит ажилд хамтран ажиллаж, иргэдэд өөрсдийн хувийн мэдээллийг хамгаалах талаарх мэдлэг ойлголт өгөхөөр танилцуулга, зурагт хуудасны агуулгыг боловсруулан нийгмийн мэдээллийн сүлжээнд байршуулан олон нийтэд хүргэж байна.

2. Мэдээлэл, харилцаа холбооны салбарын томоохон төслүүдийн бэлтгэн нийлүүлэх, туслан гүйцэтгэх үйл ажиллагаанд оролцож байгаа үндэсний жижиг, дунд үйлдвэрүүдийн тухай:

Мэдээлэл харилцаа холбооны салбарт гадаадын зээл, тусламж, улсын төсөв, нийслэлийн болон өөрийн хөрөнгө оруулалтаар нийт 13078 тэрбум төгрөгийн 109 төсөл, арга хэмжээ хэрэгжиж байгаагаас Улсын болон нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт, өөрийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа 57 төсөл, арга хэмжээнээс 30 төслийн гүйцэтгэгчээр үндэсний компаниуд шалгаран ажиллаж байна. Мэдээлэл, харилцаа холбооны салбарын томоохон төслүүдийн бэлтгэн нийлүүлэх, туслан гүйцэтгэх үйл ажиллагаанд оролцож байгаа үндэсний жижиг, дунд үйлдвэрүүдийн оролцоо бага байгаа. Учир нь гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төслүүд нь дотроо багц төслүүдэд хуваагдаж байгаа бөгөөд эдгээрээс харилцаа холбоо мэдээллийн технологийн чиглэлээр төслүүдийн задаргааг нарийвчлан гаргаж, мэдээлэл ирүүлдэггүй. Мөн өмнөх онуудаас хэрэгжиж байгаа төсөл арга хэмжээнүүд байгаагаас тайлант хугацаанд тухайн онд хийсэн болон төсөвт зарцуулагдсан төсвийн задаргааг тусгаж өгөөгүйгээс тайланг нэгтгэхэд төсөвт өртөг давхацсан байдлаар гарах асуудал байна.

3. Төрийн байгууллагаас мэдээллийн технологийн чиглэлээр хэрэгжүүлж байгаа болон хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн тухай.

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанаас Цахим засаглалыг бэхжүүлэх чиглэлээр 2024 он хүртэл хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүнг тодорхойлохыг даалгасны дагуу тус яамнаас 2022 оны 07 дугаар сард Засгийн газрын гишүүд болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт өөрийн байгууллага болон салбар, харьяа байгууллагын хүрээнд 2024 он хүртэл хэрэгжүүлэхээр төлөвлөж буй нийтийн мэдээллийн дэд бүтэц, төрийн цахим үйл ажиллагаанд хамаарах цахим төсөл, хөтөлбөр, арга хэмжээний талаарх мэдээллийг ирүүлэх шаардлага хүргүүлсэн.

Үүний дагуу Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Шадар сайдын харьяа байгууллагууд болон яамдаас нийт 175 төсөл, арга хэмжээ /128 байгууллага/-г, аймаг, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон тэдгээрийн харьяа байгууллагаас нийт 182 төсөл, арга хэмжээ /76 байгууллага/-г 2024 он хүртэл тус тус хэрэгжүүлэхээр төлөвлөсний 128 төсөл улсын төсвөөр, 37 төсөл зээл тусламжаар, 76 төсөл өөрийн санхүүжилтээр, 18 төсөл төр хувийн хэвшлийн түншлэлээр, 62 төсөл санхүүжилт нь тодорхойгүй байна.

Мэдээллийн технологийн төсөл, хөтөлбөр, инновацыг дэмжих зорилгоор 2022 оны 09 дүгээр сарын 14-ний өдөр Засгийн газрын хуралдаанаар “Цахим хөгжил, харилцаа холбооны яам, түүний харьяа болон салбар байгууллагыг Буянт-Ухаа олон улсын нисэх буудлын зорчигч үйлчилгээний барилгын тодорхой хэсэгт байршуулахтай холбоотой тооцоо, судалгааг хийж нүүлгэн шилжүүлэх” Ажлын хэсэг гарч холбогдох тооцоо судалгааг хийж байна.

Мөн Цахим хөгжил, харилцаа холбооны салбарт 2022 онд 11 төсөл арга хэмжээнд нийт 6.3 тэрбум төгрөгийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэхээр батлагдсан. Тус онд Хөдөөгийн алслагдсан багуудыг холбоожуулах, 4G сүлжээний үйлчилгээ /Хөвсгөл, Арбулаг, Тариалан, Ренчинлхүмбэ, Улаан-Уул, Эрдэнэбулган, Бүрэнтогтох, Цэцэрлэг, Чандмань-Өндөр, Төмөрбулаг, Цагаан-Үүр сум/, Хөдөөгийн алслагдсан багуудыг холбоожуулах, сүлжээний өргөтгөл /Хөвсгөл, Жаргалант, Галт, Төмөрбулаг, Тосонцэнгэл, Их-Уул, Рашаант сум/, Шилэн кабельд холбох, зураг төсөв боловсруулах /Баян-Өлгий, Улаанхус сум, Хөх хөтөл баг/, Мэдээлэл холбооны Дархан

дэд төв /Дархан-Уул, Дархан сум, 1, 2, 3 дугаар баг/, Хөдөөгийн алслагдсан багуудыг холбоожуулах, 4G сүлжээний үйлчилгээ /Сүхбаатар, Асгат, Баяндэлгэр, Мөнххаан, Онгон, Сүхбаатар, Эрдэнэцагаан сум/, Үүрэн сүлжээний антен /Ховд/, Үүрэн холбооны дахин дамжуулах сүлжээ станц /Хөвсгөл, Цэцэрлэг, Их-Уул, Тариалан сум/, Хөдөөгийн алслагдсан багуудыг үүрэн холбооны сүлжээнд холбох /Хөвсгөл/, Хөдөөгийн алслагдсан багуудыг холбоожуулах, 4G сүлжээний үйлчилгээ /Архангай, Өндөр-Улаан сум, Азарга баг, Ихтамир сум, Бугат, Хөхнуур баг, Тариат сум, Алтаад баг/, Сумдад төрийн цахим үйлчилгээг нэвтрүүлэх "Хур" систем /Улсын хэмжээнд/, Төрийн үйлчилгээг ил тод, нээлттэй болгох "Олон талт түншлэл" цахим хөтөлбөр /Орхон/ төсөл, арга хэмжээ хэрэгжиж байна.

Хуулийн дугаар	Төсөл, хэмжээний байршил арга нэр,	Хугацаа		Нийт төсөвт өртөг /сая.төг/	2023 онд Санхүүжих дүн /сая.төг/	Гэрээний дүн /төгрөгөөр/	Гүйцэтгэгч компанийн нэр
		Эхлэх	Дуусах				
XXIX	Цахим харилцаа хөгжил, холбооны сайд			38,218.8	6,384.8	36,612,354,002.4	
XXIX.1.1	I. Барилга байгууламж			13,418.8	4,699.0		
	Шилжих			3,123.8	1,484.0		
XXIX.1.1.1	Хөдөөгийн алслагдсан багуудыг холбоожуулах, 4G сүлжээний үйлчилгээ /Хөвсгөл, Арбулаг, Тариалан, Ренчинлхүмбэ, Улаан-Уул, Эрдэнэбулган, Бүрэнтогтох, Цэцэрлэг, Чандмань-Өндөр, Төмөрбулаг, Цагаан-Үүр сум/	2021	2023	1,723.8	216,6	1,716,572,636	Эйч ти эл ХХК
XXIX.1.1.2	Хөдөөгийн алслагдсан багуудыг холбоожуулах, сүлжээний өргөтгөл /Хөвсгөл, Жаргалант, Галт, Төмөрбулаг, Тосонцэнгэл, Их-Уул, Рашаант сум/	2020	2022	800.0	100.0	796,000,000.0	Юнител ХХК
XXIX.1.1.3	Шилэн кабельд холбох, зураг төсөв боловсруулах /Баян-Өлгий, Улаанхус сум, Хөх хөтөл баг/	2021	2022	600.0	184.0	585,990,261.0	5 багц Он дамжин хэрэгжиж байгаа, эрх шилжсэн (Классиксолушн ХХК, Файвер оптик констракшин ХХК)
	Шинэ			10,295.0	3,215.0		
XXIX.1.1.4	Мэдээлэл холбооны Дархан дэд төв /Дархан-Уул, Дархан сум, 1, 2, 3 дугаар баг/	2022	2023	6,500.0	5933,7	6,373,712,734.0	"Бигмонголиа билдинг" ХХК ЦХХХЯ/202201001

XXIX.1.1.5	Хөдөөгийн алслагдсан багуудыг холбоожуулах, 4G сүлжээний үйлчилгээ /Сүхбаатар, Асгат, Баяндэлгэр, Мөнххаан, Онгон, Сүхбаатар, Эрдэнэцагаан сум/	2022	2022	800.0	800.0	592,000,000.0	Юнител ХХК Сүхбаатар аймагт эрх шилжсэн.
XXIX.1.1.6	Үүрэн сүлжээний антен /Ховд/	2022	2022	400.0	400.0	394,278,455.0	"Мянган Өндөр Цахир" ХХК ЦХХХЯ/202201008
XXIX.1.1.7	Үүрэн холбооны дахин дамжуулах сүлжээ станц /Хөвсгөл, Цэцэрлэг, Их-Уул, Тариалан сум/	2022	2022	595.0	595.0	593,412,730.0	"Монкабель" ХХК ЦХХХЯ/202201003
XXIX.1.1.8	Хөдөөгийн алслагдсан багуудыг үүрэн холбооны сүлжээнд холбох /Хөвсгөл/	2022	2023	1,500.0	883,9	1,383,866,236.0	"Эйч Ти Эл" ХХК ЦХХХЯ/202201006
XXIX.1.1.9	Хөдөөгийн алслагдсан багуудыг холбоожуулах, 4G сүлжээний үйлчилгээ /Архангай, Өндөр-Улаан сум, Азарга баг, Ихтамир сум, Бугат, Хөхнуур баг, Тариат сум, Алтаад баг/	2022	2022	500.0	500.0	490,207,367.0	"Цагаансүмбэр" ХХК ЦХХХЯ/202201007
XXIX.1.3	III. Тоног төхөөрөмж			24,800.0	1,685.8		
	Шилжих			24,800.0	1,685.8		
XXIX.1.3.1	Сумдад төрийн цахим үйлчилгээг нэвтрүүлэх "Хур" систем /Улсын хэмжээнд/	2019	2022	23,000.0	585.8	21,922,375,583.4	27 багц- он дамжин хэрэгжиж байна.
XXIX.1.3.2	Төрийн үйлчилгээг ил тод, нээлттэй болгох "Олон талт түншлэл" цахим хөтөлбөр /Орхон/	2021	2022	1,800.0	1,100.0	1,763,938,000	Баганадант ХХК, Орхон аймагт эрх шилжсэн, он дамжин хэрэгжиж байна.

4. Гадаад улсын элчин сайд болон бусад төлөөлөгчидтэй уулзсан уулзалтын ярианы тэмдэглэл, байгуулсан гэрээ хэлэлцээр, санамж бичгийн талаар:

Цахим хөгжил, харилцаа холбооны яамны хэмжээнд 2022 оны 10 дугаар сарын 17-ны өдрийг хүртэлх хугацаанд дараах уулзалтуудыг зохион байгуулж ажилласан байна. Үүнд:

- Монгол улсын цахим шилжилтийн салбарт холбогдох бодлого, дүрэм, журмын дагуу Монгол Улсыг дижитал эдийн засагт шилжүүлэх, улс орны цахим өрсөлдөх чадварыг сайжруулах үйл ажиллагаанд хамтран ажиллах тухай Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Европын сэргээн босголт хөгжлийн банк хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан.

- 2022 оны 04 дүгээр сард Цахим хөгжил, харилцаа холбооны яамны тухайн үеийн Төрийн нарийн бичгийн дарга Б.Болор-Эрдэнэ, Эстони улсын Цахим

Засаглалын академийн Гүйцэтгэх захирал Ханнес Асток нар Цахим хөгжил, харилцаа холбооны яам болон Бүгд Найрамдах Эстони Улсын Цахим засаглалын академи хоорондын Цахим засаглалын чиглэлээр хамтран ажиллах харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан.

- 2022 оны 06 дугаар сард Монгол Улсын Засгийн газар Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага /ЖАЙКА/-н нарийвчилсан төлөвлөлтийн судалгааны багтай хамтран “Кибер аюулгүй байдлын хүний нөөцийг хөгжүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлэхээр гэрээнд Монгол Улсыг төлөөлж, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны тухайн үеийн Төрийн нарийн бичгийн дарга Б.Болор-Эрдэнэ, ШУТИС-ийн Мэдээлэл холбооны технологийн сургуулийн захирал Н.Чулуунбанди, ЖАЙКА-ийн талаас Нарийвчилсан судалгааны багийн дарга Идэ Хироюуки нар тус тус гарын үсэг зурсан.

- 2022 оны 06 дугаар сард Цахим хөгжил, харилцаа холбооны яамны тухайн үеийн Төрийн нарийн бичгийн дарга Б.Болор-Эрдэнэ, KDDI сангийн олон улсын хамтын ажиллагааны газрын дэд дарга Ноён Kazunori Fujita, ахлах зөвлөх Ноён Yosuke Uchiyama, зөвлөх менежер Ноён Toshizkazu Yurugi болон Далайн кабель болон харилцаа холбоо компанийн ахлах менежер Ноён Hiroki Yanagisawa нартай уулзаж цахим хөгжил, харилцаа холбооны салбарт одоо хэрэгжүүлж буй төсөл болон цаашид хэрэгжүүлэх “Программ хангамж, робот зэрэг мэдээлэл технологийн боловсролыг бага насны хүүхдэд олгох” төслийн талаар санал солилцов.

Тус яам Ази Номхон далайн цахилгаан холбооны байгууллага /АРТ/-ийн дэмжлэгээр мэдээлэл, харилцаа холбооны шинэ технологийг дэмжих, мэдээллийн технологийн өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг хангах, шинэ шийдлийг нэвтрүүлэх, алслагдсан бүс нутгийг мэдээллийн технологиор хангах зорилгоор “Монгол Улсын хөдөө орон нутагт шинэ технологийн шилэн кабелийг элсэрхэг хөрс, хүйтэн бүсэд суурилуулан турших, хэрэглэгчдэд интернэт сүлжээ хүргэх”, “Алслагдсан бүс нутагт FM радиог ашиглан гамшгийн үеийн мэдээ, мэдээлэл дамжуулах” төслүүдийг Япон улсын KDDI сантай хамтран хэрэгжүүлж байгаа ба төсөл хэрэгжсэнээр тоног төхөөрөмж суурилуулсан алслагдсан бүс нутгийн иргэдийг гамшгийн үеийн мэдээ, мэдээллээр түргэн шуурхай хангах боломж бүрдэнэ.

- 2022 оны 07 дугаар сард Цахим хөгжил, харилцаа холбооны яамны тухайн үеийн Төрийн нарийн бичгийн дарга Б.Болор-Эрдэнэ Ирланд Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайд Анн Дервин, нэгдүгээр нарийн бичгийн дарга Жозеф Китинг нартай уулзаж, Төрийн нарийн бичгийн дарга Б.Болор-Эрдэнэ Монгол Улс дахь цахим шилжилтийн үйл явц, туршлагын талаарх мэдээллийг Ирланд улсын Элчин сайдад танилцуулан, Монгол Улсад хөдөө аж ахуйн салбарын цахим шилжилтэд хамтран ажиллах талаар санал солилцсон.

- 2022 оны 08 дугаар сард Цахим хөгжил, харилцаа холбооны яамны удирдлагууд НАСА-гийн Олон улсын болон агентлаг хоорондын харилцааны албаны Олон улсын хөтөлбөрийн мэргэжилтэн Бетси Голдемен, Олон улсын оффисын Ази дахь төлөөлөгч Гарви Макинтош нартай цахим хэлбэрээр уулзалт зохион байгуулж Монгол Улсын сансар судлалын салбарын мэргэжилтнүүдийн ур чадварыг дээшлүүлэх НАСА-ийн зүгээс дэмжлэг үзүүлэх, тодорхой төсөл хөтөлбөрүүдийг хамтран хэрэгжүүлэхээр тогтсон.

- 2022 оны 08 дугаар сард Орос-Монгол хоёр орны хооронд дипломат харилцаа тогтоосны 100 жилийн ойн хүрээнд, 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдөр болсон, Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх, ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин нарын албан ёсны уулзалтаар, хоёр улсын сансрын салбарын хамтын ажиллагааны шинэ үеийг эхлүүлэх санал дэвшүүлсний дагуу Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Оросын холбооны улсын “Роскосмос” сансар судлалын улсын үйлдвэрийн газартай хамтран ажиллах санамж бичигт Цахим хөгжил, харилцаа холбооны яамны тухайн үеийн Төрийн нарийн бичгийн дарга буюу Сансрын үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга Б.Болор-Эрдэнэ, ОХУ-аас Роскосмос улсын үйлдвэрийн газрын, Олон улсын

хамтын ажиллагаа хариуцсан ерөнхий захирлын орлогч Савельев Сергей Валентинович нар цахим хэлбэрээр гарын үсэг зурлаа. Энэхүү хамтын ажиллагааны хүрээнд сансрын уудмыг энхийн зорилгоор судлах, ашиглах, Монгол Улсын анхны эмэгтэй сансрын нисэгчийг хөөргөх, хоёр орны сансар судлалын салбарт хамтын ажиллагааг эрчимжүүлэх зорьж байна.

- 2022 оны 09 дүгээр сард Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Дэлхийн банкны төлөөллүүдтэй уулзаж, 2015-2022 онд Дэлхийн банкны санхүүжилттэй “Ухаалаг засаг I” төсөл амжилттай хэрэгжиж дууссантай холбогдуулан хоёр дахь төсөл болох “Ухаалаг засаг II” төслийн талаар санал солилцов. Энэ хүрээнд иргэд, аж ахуйн нэгжид үзүүлж буй цахим үйлчилгээний хэрэглээ, үр ашгийг сайжруулах, дижитал ур чадварыг нэмэгдүүлэх, дижитал технологид суурилсан ажлын байрыг нэмэгдүүлэх замаар дижитал шилжилт хийх боломжтой болох талаар хэлэлцсэн.

Уг төсөл хэрэгжсэнээр төрийн бүх шатны байгууллага дотроо, өөр хоорондоо, төрийн байгууллагаас иргэн, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагатай цахим хэлбэрээр харилцах орчин нөхцөлийг бүрдүүлж, Цахим Монгол хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулахаас гадна төрийн цахим үйлчилгээний хүртээмж, дэд бүтэц, аюулгүй байдлыг сайжруулж, үүлэн тооцооллын нэгдсэн систем ашигласнаар төсвийн хэмнэлт хийх боломжтой болох ба 10000 иргэн, 3000 төрийн албан хаагчийн дижитал ур чадварыг нэмэгдүүлснээр дижитал шилжилтийг хурдасгах ач холбогдолтой гэж үзсэн.

- 2022 оны 08 дугаар сард ЦХХХЯ-ны тухайн үеийн Төрийн нарийн бичгийн дарга Б.Болор-Эрдэнэ АНУ-н Сансар судлалын агентлаг /НАСА/-тай цахим уулзалт хийж, хамтран ажиллахаар санал солилцсон бөгөөд тус уулзалтаар Монгол Улсын сансар судлалын салбарын мэргэжилтнүүдийн ур чадварыг дээшлүүлэх НАСА-ийн зүгээс дэмжлэг үзүүлэх, тодорхой төсөл хөтөлбөрүүдийг хамтран хэрэгжүүлэхээр тогтсон. Сүүлийн үед дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй экологийн тэнцвэрт байдал алдагдаж, байгалийн гамшигт үзэгдлийн давтамж нэмэгдэж байгаа нь энэ чиглэлийн нарийвчилсан судалгааг сансрын технологитой хослуулан хийх, нөхцөл байдлын үнэлгээг олон жилийн тоон мэдээлэл дээр үндэслэн гаргах, болзошгүй эрсдэлийг урьдчилан таамаглах зэрэг шаардлагууд тулгарч байгааг онцлон манай улсын хувьд энэ чиглэлийн судалгааны ажлууд дээр АНУ-ын Сансар судлалын агентлаг /НАСА/-ийн дэмжлэгийг авч ажиллахаар болсон.

- 2022 оны 08 дугаар сард Цахим хөгжил, харилцаа холбооны яамны тухайн үеийн Төрийн нарийн бичгийн дарга Б.Болор-Эрдэнэ, Бодлого төлөвлөлтийн газрын дарга З.Гантоогоо, Харилцаа холбооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Х.Энхманлай нар “SpaceX” компанийн ерөнхийлөгч Gwynne Shotwell болон Элон Маскийн багийнхантай цахим уулзалт хийж, Старлинк төслөөс гадна Элон Маскийн сэргээгдэх эрчим хүчний төсөл болох “Solarcity” болон “Hyperloop” төслүүдийг Монголд хэрэгжүүлэх боломжит нөхцөлийн талаар санал солилцлоо. Цахим хөгжил, харилцаа холбооны яам 2022 онд “Нам орбитын хиймэл дагуулын сүлжээ ашиглахад баримтлах чиглэл”-ийг баталсан ба уг бодлогын баримт бичиг Старлинкийн үйл ажиллагааны стратегитай хэрхэн уялдаж байгаа талаар онцлон санал солилцсон.

- 2022 оны 09 дүгээр сард Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Америкийн Нэгдсэн Улсын Элчин сайдтай Буянт-Ухаад мэдээлэл технологийн шилдэг 20 компанийг нэгтгэж “HUB” үүсгэх төлөвлөгөөний хүрээнд хамтран ажиллах уулзалт хийлээ. Уг уулзалтаар Америкийн Нэгдсэн Улсын Элчин сайд цаашид стратегийн гол ажлууд буюу мэдээллийн технологийн аудит, стандарт зэрэг ажлууд дээр бодлогын чиглэлээр хамтран ажиллах туршлага хуваалцахаа илэрхийлсэн.

- Кибер аюулгүй байдлын инновац, технологийг хөгжүүлэх хүрээнд олон улсад судалгаа, шинжилгээ болон нэвтрүүлэлтийг амжилттай хэрэгжүүлсэн байгууллага буюу “MITRE” ашгийн бус байгууллагын төлөөллүүд хамтран ажиллах санал солилцох уулзалтыг зохион байгуулав. Энэ хүрээнд “Кибер аюулгүй байдлын ажиллах хүчний

хөгжил” (Cyber workforce development workshop) сэдэвт сургалт зохион байгуулсан ба ингэснээр салбарын албан хаагчдын мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх цаашлаад хүний нөөцийг бэлтгэх үндэс суурь тавигдана.

- 2022 оны 09 дүгээр сард Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал “Мета” компанийн Төв Ази, Монгол, Хятадыг хариуцсан олон нийтийн бодлогын газрын захирал Жорж Ченд “Найрамдлын одон” гардуулж, уулзалт хийв. “Мета” компани бүс нутгийн шинэ дата төвийг байгуулах байршлаа тодорхойлохоор ажиллаж байгаа бөгөөд 2021 оны 2 дугаар сард МУ-ын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ “Мета” компанийн дата төвийг МУ-д байгуулах боломжтой тухай саналаа илэрхийлж байсан. Үүний дагуу “Мета” компанийн Төв Ази, Монгол, Хятадыг хариуцсан олон нийтийн бодлогын газрын захирал Жорж Чен болон Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал нар санал солилцсон.

- 2022 оны 09 дүгээр сард Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал дэлхийн 176 улсад салбартай, 200 гаруй мянган ажилчидтай дэлхийн шилдэг 500 технологи үйлдвэрлэгчдийн 44-рт эрэмбэлэгддэг “Huawei” компанийн төлөөлөлтэй уулзалт хийв. Уулзалтаар “Huawei” компанийн зүгээс боловсрол, эрүүл мэндийн салбарын цахим шилжилтэд шаардлагатай технологийн шийдэл дээр болон 5G сүлжээ, сэргээгдэх эрчим хүчний салбарт, дата төв байгуулах зэрэг томоохон санаачилгуудыг хамтран хэрэгжүүлэх боломжтой гэдгээ илэрхийлсэн бол Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал Радио телевизийн үндэсний сүлжээг тоон системд шилжүүлэх, боломжит 350 га талбайд нарны панель байгуулах, боомтуудыг шилэн кабелиар холбох гэх мэт ажлуудад судалгаа, тооцоог нарийвчлан боловсруулж, харилцан ашигтай хамтран ажиллах боломжтойг илэрхийлсэн.

- 2022 оны 09 дүгээр сард Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал Европын холбооны элчин сайд А.Никейзийг хүлээн авч уулзав. Уулзалтаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайд мэдээллийн технологийн 20 компанийг HUB хэлбэрээр байршуулахаар төлөвлөж байгаагаа дурдаж, томоохон ажлуудыг цогцоор нь шийдэхийг зорьж байгаагаа илэрхийллээ. Европын холбооны элчин сайд А.Никейз Монгол Улс, Европын Холбоо хоорондын 2017 онд байгуулсан Түншлэл, Хамтын ажиллагааны Хэлэлцээрийн дунд хугацааны төлөвлөгөөг 2021 онд Европын Холбооны 27 улс нийлж баталсныг дурдаж гол ажил болох e-agriculture буюу хөдөө аж ахуйн салбарт цахим шилжилтийг нэвтрүүлэх ажил хийгдэж байгаа тухай туршлагаа хуваалцав.

- 2022 оны 09 дүгээр сард Цахим хөгжил, харилцаа холбооны дэд сайд Б.Болор-Эрдэнэ Microsoft компанийн удирдлагуудтай цахим уулзалт хийж, олон талын хамтын ажиллагааг албан ёсоор эхлүүллээ. Төрийн албан хаагчид лицензгүй программ хангамж хэрэглэж байгаа нь мэдээллийн аюулгүй байдлын хувьд тулгамдаж буй асуудал болоод байгааг дурдаж, нэн шаардлагатай 21000 төрийн албан хаагчдыг үе шаттайгаар лицензтэй, аюулгүй байдал хангагдсан программ хангамжаар хангах гэрээ, хэлэлцээрийг ийнхүү эхлүүлсэн зэрэг ажлууд дээр санал солилцсон.